

**Ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн
асуудал эрхэлсэн
НҮБ-ын Тусгай илтгэгч Монгол улсад айлчилна**

ЖЕНЕВ (2018 оны 4-р сарын 5) – Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Лео Хеллер Монгол Улсын Засгийн газрын урилгаар 4-р сарын 9-өөс 4-р сарын 20-ны хооронд Монгол улсад айлчилна.

Хеллерийн айлчлалын гол зорилго нь ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, хүртээмж, чанар, иргэдийн худалдан авах чадавхийн талаар баримт мэдээлэл цуглуулахдаа, хүн амын тодорхой бүлэг, тухайлбал эмэгтэйчүүд, охид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн хөдөө орон нутгийн иргэдийн нөхцөл байдалтай нарийвчлан танилцах юм.

“Би Улаанбаатар хот болон Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций сум, мөн эдгээр хот суурин газруудын ойр орчмын газар нутгаар ажиллаж, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжтай байх хүний эрхээ Монгол хүн болгон эдлэхэд юу саад болж байгаа ба цаашдаа юу хийх шаардлагатайг судлан гаргах болно”, гэж Хэллэр хэллээ.

Айлчлалынхаа үеэр Хеллер төр засаг, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны түнш байгууллагуудын төлөөлөгчид, иргэний нийгмийн идэвхтнүүд, хот, хөдөөгийн иргэд, НҮБ-ын албан тушаалтнуудтай уулзана.

Тусгай илтгэгч нь ажиглалтын урьдчилсан дүнгээ 4-р сарын 20-ны өдрийн 11:00 цагт Монгол улс дахь НҮБ-ын төв байранд (СБ дүүрэг, НҮБ-ын гудамж 14) болох хэвлэлийн бага хурлын үеэр танилцуулна. Хэвлэлийн бага хуралд зөвхөн сэтгүүлчдийг урьж байна.

Тусгай илтгэгч нь айлчлалын үеэр цуглуулсан мэдээлэлд үндэслэн зөвлөмж бүхий тайлан гаргаж 2018 оны 9-р сард болох Хүний Эрхийн Зөвлөлийн 39 дүгээр чуулганд танилцуулна.

ТӨГСӨВ.

Ноён Лео Хеллер (Бразил) нь хүний эрх ба ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчээр 2014 оны 11-р сард томилогджээ. Тэрээр Бразил дахь Освальдо Круз Сангийн судлаачаар ажилладаг бөгөөд 1990-2014 онуудад Бразилийн Минаш Гераиш мужийн Холбооны Их Сургуулийн Ариун цэвэр, байгаль орчны инженерийн салбарын профессороор ажиллаж байжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.ohchr.org/SRwaterandsanitation> -ээс үзнэ үү.

@srwatsan хаягаар Тусгай илтгэгчийг дагана уу.

Тусгай илтгэгчид нь Хүний эрхийн Зөвлөлийн Тусгай процедур хэмээх хэсэгт харъяалагддаг. Энэхүү Тусгай процедур нь НҮБ-ын Хүний Эрхийн тогтолцоон дахь хараат бус шинжээчдийн хамгийн том хэсэг бөгөөд Зөвлөлийн зүгээс тодорхой улс орны нөхцөл байдал болон тодорхой сэдвийн талаар дэлхийн аль ч хэсэгт хараат бусаар ажиллаж, баримт нотолгоо цуглуулах, тандалт судалгаа хийх, хяналтын үүрэг гүйцэтгэх механизмын ерөнхий нэр юм. Тусгай процедурын шинжээчид нь НҮБ-ын ажилтнууд биш бөгөөд сайн дурын үндсэн дээр ажиллаж, хийсэн ажлынхаа төлөө цалин хөлс авдаггүй. Тэд аливаа улсын засгийн газар, байгууллагад харъяалагддаггүй бөгөөд зөвхөн мэргэжилтнийхээ хувьд томилогдож албан үүргээ гүйцэтгэдэг.

НҮБ-ын Хүний Эрх: [Mongolia](#)

Дэлгэрэнгүй мэдээлэл болон хэвлэлийн мэдээллийн талаар доорхи хүмүүстэй холбоо барина уу:

Айлчлалын үеэр: **Ахрейм Ли**, +41 79-752 0481/ahreumlee@ohchr.org, **Цэцэгмаа Амар** (+976 11 327 585 ext 1104/tsetsegmaa.amar@one.un.org).

НҮБ-ын хараат бус шинжээчдийн талаархи мэдээлэл авахыг хүсвэл дараахь хүмүүстэй холбогдоно уу: **Жэрэми Лаурэнс**, НҮБ-ын Хүний эрх – хэвлэл, мэдээллийн хэсэг (+41 22 917 9383 /jlaurence@ohchr.org)

НҮБ-аас 1948 оны 12-р сарын 10-ны өдөр баталсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын баримт бичгийн 70 жилийн ой 2018 онд тохиож байна. Дэлхийн 500 хэлнээ орчуулагдаж дээд амжилтыг тогтоосон энэхүү Түгээмэл Тунхаглал нь “Хүн бүр эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш төрдөг” гэсэн үндсэн зарчмыг эрхэмлэн дээдэлдэг. Энэ зарчим нь хүн болгоны өдөр тутмын амьдралд одоо ч хамааралтай хэвээр байна. Энэхүү онцгой ач холбогдолтой, нөлөө бүхий баримт бичгийн 70 жилийн ойг тэмдэглэхдээ бид түүнд тусгагдсан амин чухал зарчмуудыг эрхэмлэн дээдэлж, хүний эрхийг хангах, хамгаалах үйлсэд тууштай зогсож, хувь нэмрээ оруулахыг хүн болгонд уриалж байна. www.standup4humanrights.org.